



309.

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 88

Мөрөн

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө төлөвлөх, олж авах, бүртгэх худалдах, шилжүүлэх, актлах журмыг 01 дүгээр хавсралтаар, аймаг, сумын болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг 02 дугаар хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Л.Ганболд/, Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/, хуулийн этгээдийн дарга захирал, эрхлэгч наарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 46 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Цогтоо/-дүүрэг болгосугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР



010406

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 05 дугаар 01-ний өдрийн
22 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт

**ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ҮНДСЭН ХӨРӨНГӨ ТӨЛӨВЛӨХ, ОЛЖ АВАХ,
БҮРТГЭХ, ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХ, АКТЛАХ ЖУРАМ**

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд /цаашид хуулийн этгээд гэх/-ийн үндсэн хөрөнгө олж авах ажлыг төлөвлөх, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах үйл ажиллагааг зохицуулхад оршино.

1.2. Хуулийн этгээд үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө /цаашид хөрөнгө/-ийг төлөвлөх, олж авах, худалдах, шилжүүлэх, актлах тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцож тайлагнахад энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Тухайн хуулийн этгээдийн жилийн төсөвт нэр зааж тусгагдаагүй худалдан авах ажиллагаа зохион байгуулах хөрөнгийг энэхүү журамд заасан бүрдүүлэх баримт бичгийн дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газраас олгогдсон зөвшөөрлийн дагуу худалдан авалтыг зохион байгуулж бүртгэнэ.

1.4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 39 дүгээр тогтоолын дагуу анхны үнэ нь 2,0 сая хүртэлх төгрөгөөс өртөгтэй хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах үйл ажиллагааг Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.

1.5. Орон нутгийн өмчит болон оролцоотой компани, үйлдвэрийн газар, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний орон нутгийн өмчит хэлтэс, агентлаг, байгуулага, Аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн ИТХ-аас хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах үйл ажиллагааг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.

Хоёр. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ

2.1. Хуулийн этгээд нь үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв хөрөнгө оруулалтын дагуу болон төсвийн зохицуулалтаар эх үүсвэр бий болгосон хөрөнгөөр худалдаж авах, төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, мөн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.

2.2. Хуулийн этгээд дараа онд хэрэгцээтэй байгаа улсын болон орон нутгийн урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авах үндсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлага, нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, зардлын хэмжээг тусгасан захиалгаа Төсвийн тухай хуулийн дагуу жил бурийн 7-р сарын 5-25-ны дотор Орон

нутгийн өмчийн газарт ирүүлнэ. Энэ нь дараа онд хөрөнгө худалдан бэлтгэх зөвшөөрөл олгох үндэслэл болно.

2.3. Хуулийн этгээд аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого зохицуулалтын хэлтсээр дамжуулан дараа онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх орон нутгийн өмчийн шинээр барилга байгууламж барих, тээврийн хэрэгслийн парк шинэчлэл хийх, барилга байгууламжид их засвар, өргөтгөл шинэчлэл хийх хөрөнгө оруулалтын саналаа 2-р сарын 15-ны дотор ирүүлж улсын бодлого төлөвлөлтийн тухай хууль 12 дугаар зүйл/

2.4. Хуулийн этгээд орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэх орон нутгийн өмчийн шинээр барилга байгууламж барих, тээврийн хэрэгслийн парк шинэчлэл хийх, барилга байгууламжид их засвар, өргөтгөл шинэчлэл хийх хөрөнгө оруулалтын саналаа 10-р сарын 05-ны дотор тухайн шатны ИТХ-ын өргөн мэдүүлж эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгувсан байна. /Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 16 дугаар зүйл/

2.5. Сум, аймаг, улсын төсвийн дараа оны үндсэн чиглэлд тусгагдаж дараа онд хийгдэх хөрөнгө оруулалтын төлөвлөхдөө байгууллагын ирээдүйн хүчин чадлын хэрэгцээ шаардлага, өнгө дизайн, газар зүй, байгаль цаг уурын онцлог зэргийг тусгасан зураг төсвийн захиалгыг сум, байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөс гаргаж холбогдох байгууллагаар зөвлөхийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2.6. Орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот хуулийн хуулийн этгээд тухайн жилийн бизнес төлөвлөгөөндөө хөрөнгө оруулалтаар хийгдэх үндсэн хөрөнгийн захиалгаа тусгаж эрх бүхий байгууллагаар батлуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

2.7. Тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэр заан тусгагдаагүй боловч зайлшгүй ажлын шаардлагаар худалдан авах хэрэгцээтэй үндсэн хөрөнгийг холбогдох бичиг баримтыг бурдүүлэн Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авч худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

Гурав. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ХУДАЛДАН АВАХ

3.1 Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг зарлаж үндсэн хөрөнгө бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа захиалагч нь өмчлөгч байж гүйцэтгэлийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж улсын комисст хүлээн авсны дараа эзэмшигч байгууллагад шилжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ

3.2. Хандив, тусламж, бэлэглэлийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө бэлтгэх бол тухайн хандив тусламж, бэлэглэл олгож байгаа эрх бүхий этгээдтэй зөвшилцсөний үндсэн дээр Худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

3.3. Тухайн байгууллагын жилийн үйл ажиллагааны төсөвт хөрөнгө худалдан авах зардалд батлагдсан, дээд шатны байгууллагаас хөрөнгө худалдан авахаар зөвшөөрсөн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг орон нутгийн өмчийн газрын

зөвшөөрөл авахгүйгээр тухайн жилийн байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулыг.

3.4. Энэхүү журмын 2.7 дахь хэсэгт заасан хөснөгийг худалдан авахдаа Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөөр доорх материалыг бурдүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

- 3.4.1. Эрх бүхий байгууллага албан тушавтгаар төсвийн зохицуулалт хийлгэсэн захирамж тушаал шийдвэр.
- 3.4.2. Худалдан авах хөрөнгийн хүчин чадал, хэмжээ, тоо хэмжээг тодорхойлсон техникийн тодорхойлолт
- 3.4.3. Худалдан авалт зохион байгуулакаар www.tender.gov.mn сайтад байршуулсан зар
- 3.4.4. Тухайн хөрөнгийн зах залмийн үнийн судлаал
- 3.4.5. Байгууллагын санч хамгаалак байнгын залгамжийн шийдвэр
- 3.4.6. Байгууллагын цагдаа эрдэгчийн тосогтын сэргээлийн аважыг жүссэн албан бичиг
- 3.4.7. Тухайн хөрөнгийг худалдах, худалдан авах гарзный загвар

Дараа. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БҮРТГАХ

4.1. Хуулийн этгээд нь энэ журмын 3.1 дахь хэсэгт заасан хөрөнгийг бүртгэхдээ захиалагчаас бетапсан улсын комисс ажиллаж ашиглалтанд хүлээн авсны дараа эзэмшигч хуулийн этгээд дараах баримтыг бурдүүлэн байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусган а.

- 4.1.1. Ажлын зураг тасв
- 4.1.2. Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээ
- 4.1.3. Гүйцэтгэлийн зураг тасв
- 4.1.4. Улсын комисс түлээн авсан алт
- 4.1.5. Ил далд ажлын акт
- 4.1.6. Техникийн тодорхойлолт хүчин чадлын тодорхойлсон жувийн хэрэг, техникийн паспорт гарчилгээ, тохирлын гарчилгээ

4.1.7. Захиалагч байгууллагад эзэмшигчид шилжүүлэх тухай шийдвэр зэргийг үндэслэж байгууллагын хөрөнгөд бүртгэнэ.

4.2. Хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулж бий болгосон үндсэн хөрөнгийг улсын комисс хүлээн авсны дараа 4.1.1-4.1.7 дахь баримтыг үндэслэн аймгийн Basag даогын заасан замжаар хөрөнгөд бүртгэнэ

4.3. Хандив, тусгамт боломжлээр өвлийн түншэн хөрөнгийг хүлээн аваад байгууллагын өмч хамгаалак байнгын газлолаар хэлбэрэн зах залдийн үнээр өртгийг тогтоож байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэнэ

4.4. Нягтлан бодох бүртгэлийн ОУ-ын стандартын дагуу барилга байгууламжийг хийц бүтээцээр үнэлж бүртгэнэ.

- 4.5. Худаг, усан санг барилга, тоног төхөөрөмжөөр нь салгаж бүртгэнэ.
- 4.6. Зураг төсвийг байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэн хадгална.
- 4.7. Шинээр бий болсон ба **ТООЛЛОГООР ИЛЭРСЭН ЭЗЭМШИГЧ НЬ ТӨДОРХОЙ** бус

хөрөнгийг Орон нутгийн өмчийн газарт албан бичгээр хандаж аймгийн Засаг даргын захирамжаар эзэмшигч тогтоож хуулийн этгээдэд хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

4.8. Хуулийн этгээд эргэлтийн хөрөнгөөс үндсэн хөрөнгөд хөрөнгө шилжүүлэн бүртгэх бол Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн хөрөнгийн үнийн дунг харгалзан аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэрээр хүлээн авсан байгууллага хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэж авна.

4.9. Дуусаагүй барилга байгууламжийг захиалагч нь гүйцэтгэлийн актыг үндэслэн өөрийн "Дуусаагүй барилга байгууламж"-ийн бүртгэлд бүртгэнэ.

4.10. Хуулийн этгээд хүлээн авсан, ашиглалтанд орсон үндсэн хөрөнгийн хувийн хэрэг, паспорт, техник үйлчилгээний картыг хөтөлж, эд хариуцагчтай гэрээ байгуулан ашиглана.

Тав. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ

5.1. Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг худалдах асуудлыг энэ журмын 1.4, 1.5 дахь хэсэгт заасны дагуу аймаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэж дуудлага худалдаагаар шийдвэрлэнэ.

5.2. Дуудлага худалдааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн ИТХТ-ийн 2017 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Дуудлага худалдаа явуулах журам"-ийн дагуу зохион байгуулна.

5.3. Хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөл дуудлага худалдаагаар шийдвэрлүүлэх хөрөнгийг аймаг сумын ИТХ-д хургуулэх өдрөөс эхлэн тухайн хөрөнгийн бүрэн бүтэн байдлын үзлэг тооллогыг хийж, акт үйлдэн битүүмжлэн харуул хамгаалалтын ажилтанд шилжүүлэн өгнө.

5.4. Дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэр гарсан хөрөнгийг битүүмжлэн хамгаалж дуудлага худалдаагаар худалдан авсан эздэд хүлээлгэн өгөх асуудлыг тухайн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл хариуцна.

5.5. Хуулийн этгээд үндсэн хөрөнгө худалдах саналаа ирүүлэхдээ дараах материалыг бурдүүлж ирүүнэ

5.5.1. Байгууллагын даргын албан бичиг, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт

5.5.2. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр /ОНӨ компани, агентлагууд хамаарахгүй/

5.5.3. Хөрөнгийн ашиглалтанд орсон огноо, балансын үнэ, үлдэгдэл үнэ

5.5.4 Сүүлийн 3 жилийн сэргээн босголт, засварын зардал

5.5.5. Улсын бүртгэлийн гэрчилгээ паспорт, хувийн хэрэг, татварын гэрчилгээ

5.5.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр

5.5.7. Хөрөнгийн гадна болон дотроос авсан гэрэл зураг /цахимаар/

5.5.8. Тээврийн хэрэгслийн хувьд улсын дугаар, мотор, арлын дугаар, нийт гүйлт км

5.5.9. Дуудлага худалдаагаар худалдах дуудах анхны үнийн санал

5.5.10 ТУХАЙН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТУХАЙН ҮЕЙИН БАЙДЛЫН ТОДОРХОЙЛСОН ӨМЧ

хамгаалах зөвлөлийн акт /Энэ нь тээврийн хэрэсэл, тоног төхөөрөмжид хамаарна/

5.6. Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийг аймаг, сумын ИТХ-аар шийдвэрлүүлэх маягтыг Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар батална.

5.7. Хуулийн этгээдээс актлахаар ирүүлсэн саналыг судлан үзэж, хөрөнгөтэй танилцаад сумын ӨХБЗ-өөс худалдан борлуулах дүгнэлт гаргаж болох ба тухайн хөрөнгө худалдан борлуулагдсан бол түүний байгууллагад ногдох орлогыг сумын орон нутгийн орлогод төвлөрүүлнэ.

5.8. Сумаас актлах санал ирүүлсэн хөрөнгийн материалыг хянаж үзээд аймгийн ӨХБЗ-өөс худалдах санал оруулж батлагдан тухайн хөрөнгө худалдагдсан бол орлого нь аймгийн орон нутгийн орлогод төвлөрнэ.

Зургаа. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ

6.1. Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшилд шилжүүлэх асуудлыг энэ журмын 1.4 дахь хэсэгт заасны дагуу аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.

6.2. Сумын ИТХ-ын шийдвэрээр зөвхөн өөрийн сумын орон нутгийн өмчийн байгууллага хооронд шийдвэрлэх болох ба өөр сумын орон нутгийн болон төрийн өмчийн бусад байгууллагад шилжүүлэх асуудлыг зөвхөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс шийдвэрлэнэ.

6.3. Хуулийн этгээд хооронд хөрөнгө шилжүүлэхэд өгөх, авах байгууллага саналаа хамтад нь албан бичгээр ирүүлнэ.

6.4. Хуулийн этгээдийн хооронд үл хөдлөх хөрөнгө шилжиж байгаа бол газар эзэмших эрх нь дагалдан шилжинэ.

6.5. Байгууллагын дотроо үндсэн хөрөнгө үндсэн хөрөнгийн данс хооронд шилжүүлэхэд өмч хамгаалах байнгынзөвлөлийн дүгнэлтийг үндэслэн байгууллагын даргын шийдвэр гаргана.

6.6. Байгууллагын дотроо үндсэн хөрөнгөөс эргэлтийн хөрөнгөд хөрөнгө шилжүүлэхэд аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр шилжүүлнэ

6.7. Орон нутгийн өмчит болон төрийн өмчит хуулийн этгээдээс бусад этгээдэд үнэ төлбөргүйгээр орон нутгийн өмчийн хөрөнгө шилжүүлэхийг хориглоно.

6.8. Үндсэн хөрөнгө шилжүүлэх маягтыг Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар батална.

Долоо. ҮНДСЭН ХӨРӨНГӨ АКТЛАХ

- 7.1. Энэ журмын 1.4-д заасан журмын дагуу аймаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар үндсэн хөрөнгө актлах асуудлыг шийдвэрлэнэ,
- 7.2. Хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг актлах шийдвэрийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдийн даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 7.3. Хуулийн этгээд үндсэн хөрөнгийг актлах саналаа аймаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр шийдвэрлүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ.
- 7.3.1. Байгууллагын даогын албан бичиг, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт
- 7.3.2. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр /агентлагууд хамаарахгүй/
- 7.3.3. Хөрөнгийн ашиглалтанд орсон огноо, дансын үнэ, үлдэгдэл үнэ
- 7.3.4. Сүүлийн 3 жилийн сэргээн босголт, засварын зардал
- 7.3.5. Улсын бүртгэлийн гэрчилгээ паспорт, хувийн хэрэг, татварын гэрчилгээ
- 7.3.6. Ашиглалтын хугацаа дусаагүй боловч эвдрэл гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл гэмтэл, хуулийн этгээдэд учирсан хохирлын хэмжээг мэргэжлийн багууллагаас тогтоосон баримт, хяналтын байгууллын шийдвэр, хохирлыг барагдуулсныг нотлох баримт
- 7.3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр
- 7.3.8. Хөрөнгийн гадна болон дотроос авсан гэрэл зураг /цахимаар/
- 7.3.9. Тээврийн хэрэгслийн хувьд улсын дугаар, мотор, арлын дугаар, нийт гүйлт км
- 7.3.10 Тухайн үндсэн хөрөнгийн тухайн үеийн байдлын тодорхойлсон Өмч хамгаалах зөвлөлийн акт /Энэ нь тээврийн хэрэсэл, тоног төхөөрөмжид хамаарна/
- 7.4. Үндсэн хөрөнгө аклах маягыг Орон нутгийн өмчийн даргын тушаалаар батална.
- 7.5. Үндсэн хөрөнгө актлах шийдвэр гарсны дараа байгууллагын даргын шийдвэрээр Өмч хамгаалах байнгын зөвлөлийг оролцуулсан устгалын комисс томилон ажиллуулна.
- 7.6. Актлагдсан хөрөнгөөс сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах боломжтой эд анги, хэсгийг ялган устгалын комиссын акт үйлдэн эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах, устгах шийдвэрийг байгууллагын дарга гаргана.

**Найм. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХЫГ ТӨЛӨВЛӨХ, ХУДАЛДАН АВАХ,
БҮРТГЭХ, ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХ, АКТЛАХ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ,
ТАЙЛАГНАХ**

- 8.1. Эрх бүхий байгууллагаас гаргасан үндсэн хөрөнгийн хөдөлгөөний шийдвэрийг Орон нутгийн өмчийн газар, үндсэн хөрөнгө эзэмшигч хуулийн этгээд, Өмч хамгаалах байнгын зөвлөлт хамтран хэрэгжүүлнэ
- 8.2. Шийдвэрийг төлөвлөж шийдвэр гарч хэрэгжүүлж дуусах хүртэлх хугацаанд энэ журмын 5.3-т заасны акт үйлдэн хадгалах, шинэ эзэмшигчид хүлээлгэн өгөх үүргийг тухайн байгууллагын дарга эрхлэгч бүрэн хариуцна.
- 8.3. Хуулийн этгээдийн дарга эрхлэгч үндсэн хөрөнгийн хариуцагч бүртэй гэрээ байгуулан жил бүр жилийн эцсийн тооллогын үр дүнгээр гэрээг дүгнэж ажиллана.
- 8.4. Сумын Засаг дарга орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга эрхлэгчтэй аймгийн Засаг дарга харьяа агентлагийн дарга эрхлэгчтэй жил бүр өмч хамгааллын гэрээ байгуулж дүгнэж ажиллана.
- 8.5. Хуулийн этгээдийн дарга, нягтлан бодогч хөрөнгө нэмэгдсэн хасагдсан, шилжүүлсэн, акталж устгасан шийдвэрийн хэрэгжилтийн талаар аймгийн Орон нутгийн өмчийн газарт гарсан шийдвэрийг /сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн толтоол/, хэрэгжилтийн хамт улирал бүрийн эхний 5-ны дотор албан бичгээр ирүүлнэ.
- 8.6. Хуулийн этгээдийн нягтлан бодогч жил бүрийн 2-р сарын 15-аас өмнө байгууллагын хөрөнгийн хөдөлгөөний тайлан мэдээг аймгийн Орон нутгийн өмчийн газарт нэгтгүүлнэ.
- 8.7. Хуулийн этгээд үндсэн хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж жилийн эцсэг сумын мэдээ, тайлант нэгтгэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд, аймгийн дүнг нэгтгэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар дараа оны 2 улиралын эхний хагаст багтааж хөлөпцуулна.

Ес.ХАРИУЦЛАГА

- 9.1. Үндсэн хөрөнгө орж авах бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах санал ирүүлэхдээ хуурамч материал бурдүүлсэн бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 дугаар зүйл, компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худэлдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэнэ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 05 дугаар 01-ний өдрийн
88. дүгээр тогтоолын 02 дугаар хавсралт

АЙМАГ, СУМЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДСЭЛЭЛ

- Сумын болон орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хуулийн этгээдийн /хуулийн этгээд/ Өмч хамгаалах байнгын зөвлөл /ӨХБЗ/-ийн үйл ажиллагааг энэхүү журнаар зохицуулна.

Хоёр. ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛ

- ӨХБЗ нь орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг олж авахыг төлөвлөх, олж авах, эзэмших, зөв зохистой ашиглах, чр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эргэлтийн болон үндсэн хөрөнгийн ашигпалтанд хяналт тавих, хөрөнгө актлаж данснаас хасах, шилжүүлэх, худалдах санал дүгнэлт гаргаж холбогдох материалыг хууль тогтоомж, журмын дагуу бүрдүүлэх, энэ талаар эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх биелэлтийг тооцох, тайлагнах ажлыг тухайн хуулийн этгээд, сум, аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах удирдлагын хэлбэр мөн.
- ӨХБЗ нь аймгийн, сумын, хуулийн этгээдийн гэсэн хэлбэртэй байна.
- ӨХБЗ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргаас гаргасан өмчийн талаар гаргасан бүхий л хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдлөг болтон ажиллана.
- Аймгийн ӨХБЗ-ийг аймгийн Засаг даргын шийдвэрээр, сумын ӨХБЗ-ийг сумын Засаг даргын шийдвэрээр, хуулийн этгээдийн ӨХБЗ-ийг байгууллагын дарга эрхлэгчийн шийдвэрээр байгуулна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4-д заасныг үндэслэн Аймгийн ӨХБЗ нь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, мэргэжилтнуудээс гадна хууль хяналт, санхүү эдийн засаг, үйлдвэрлэл үйлчилгээний бодлого хариуцсан байгууллагын төлөөлөл оролцсон 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, сумын ӨХБЗ нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөл, иргэн, ИНБ-ын төлөөлөл оролцсон 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, хуулийн этгээдийн ӨХБЗ нь байгууллагын онцлогоос хамааран 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- ӨХБЗ-ийн шийдвэр нь хурлын тэмдэглэл, түүнээс гарсан дүгнэлт байна.

Гурав. ӨХБЗ-ИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1. АЙМГИЙН ӨХБЗ-ИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 3.1.1. Аймгийн ӨХБЗ нь сум, агентлагийн орон нутгийн өмчит болон төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөнд хяналтын тооллого хийх, бүртгэл, ашиглалтын чанар байдалд үнэлгээ хийж үр дүн цаашид авах арга хэмжээний талаар аймгийн Засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх
- 3.1.2. Хуулийн этгээд хувь хунээс орон нутгийн өмчийн талаар ирүүлсэн хүсэлт санал, гомдолын дагуу хуралдаж шийдвэрлэх санал дүгнэлт боловсруулах
- 3.1.3. Хуулийн этгээдийн хооронд үүссэн өмчийн маргааныг шийдвэрлэх шийдвэрийн төсөл боловсруулах
- 3.1.4. Сум агентлагаас ирүүлсэн хөрөнгө худалдах, шилжүүлэх, актлах саналыг судлан шийдвэрийн төсөл боловсруулах
- 3.1.5. Шинээр хөрөнгө худалдан авах саналыг судлан техникийн нөхцлийг хянаж, шууд худалдан авах зөвшөөрөл олгох, ХАА-ны арга сонгох, худалдан авах ажиллагаа зохион байгуулах зөвлөмжөөр хангаж ажиллах
- 3.1.6. Улс орон нутгийн хөрөнгө, хандив зээл, тусlamжийн хөрөнгөөр хийгдэж байгаа ирээдүйд орон нутгийн өмчид үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх хөрөнгө оруулалтын явцын гүйцэтгэлд Захиалагчийг төлөөлж захиалагчийн хяналтын багийг аймгийн ӨХБЗ-өөс ахалж ажиллах
- 3.1.7. Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн орон нутгийн өмчийн хөрөнгийг хулээн авах аймгийч Засаг даргаас байгуулсан улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах ажиллах

3.2. СУМЫН ӨХБЗ-ИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 3.2.1. ӨХБЗ нь тухайн суманд чийг ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн эзэмшигд байгаа өмч хөрөнгийн бүртгэл тооллогын дүн мэдээг жил бүр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн сумын хэмжээнд хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар шийдвэр гаргуйж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө батлуулан мөрдөж ажиллах
- 3.2.2. Сумын Орон нутгийн өмчит болон төрийн өмчит байгууллагуудаас үндсэн хөрөнгө худалдах шилжүүлэх, актлахаар ирүүлсэн материалын дагуу тухайн хөрөнгийн байдал, бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт, лац битүүмжлэлийг шалгаж акт үйлдэн хулээн авч шилжүүлэх, зах зээлийн үнэлгээ тогтоох, эсвэл актальж устгах шийдвэрийн төсөл боловсруулна.
- 3.2.3. Боловсруулсан цийдээрийн төслөө энэхүү тогтоолын 1-р хавсралтын дагуу сумын Засаг дарга аймгийн Өмчийн газарт материалыг бүрдүүлж хүргүүлнэ.

- 3.2.4. Хуулийн этгээдийн өмч ашиглалт хамгаалалтанд хяналт хийхэд хөрөнгө дутагдуулсан, алдаж үрэгдуулсэн, хувьдаа ашигласан, эвдэж гэмтээсэн, зориулалтын бусаар ашигласан зөрчил илэрвэл арилгуулах ажлыг холбогдох албан тушаалтан, байгууллагад тавьж шийдвэрлүүлэн аймгийн Орон нутгийн өмчийн газарт мэдэгднэ.
- 3.2.5. Хуулийн этгээдийн түрээсээр ашиглуулах хөрөнгийн ашиглалтын гэрээг хянах, орон нутгийн орлогод түрээсийн орлого төвлөрүүлэх үйл ажиллагааг хянах
- 3.2.6. Суманд зохион байгуулгаждаж байгаа хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулах, хөрөнгө хулээпцэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
- 3.2.7. Сумын хөрөнгө Борлуулсны орлогоос СӨХБЗ-ийн дарга, гишүүдийг жилийн ажлын тайлан, орон нутгийн орлогод хөрөнгө борлуулсны орлого төвлөрүүлэлтийн үр дүнг харгалзан жилд нэг удаа 100,0 хүртэлх мянган төгрөгөөр урамшуулж болно.
- 3.2.8. Урамшуулалыг ИТХ-ын шийдвэрээр сумын Засаг дарга захирамж гаргаж олгоно.
- 3.3. Хуулийн этгээдийн ӨХБЗ-ийн эрх үүрэг**
- 3.3.1. Хуулийн этгээдийн зргэлтийн болон үндсэн хөрөнгийн ашиглалт хамгаалалт, захиран зарцуулалтанд хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлын төлөвлөгөөг байгууллагын дарга эрхлэгчээр батлуулж ажиллана.
- 3.3.2. Байгууллагын хөрөнгийн тооллогын комиссоос хагас бүтэн жилээр зохион байгуулсан тооллогын дүнг хэлэлцэж дутагдуулсан, ашиглалтгүй байгаа, цаашид ашиглах шаардлагагүй, боломжгүй болсон хөрөнгийн шалтгааныг тогтоож дутагдуулсан, илүүдэлтэй хөрөнгийн жагсаалт гарган хархан шийдвэрлэх талаар байгууллагын удирдлагад санал дутнаалт хургүүлне.
- 3.3.3. Хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа хөрөнгийн хэрэгцээг тодорхойлж, тоо хэмжээ, хүчин чадал, үнийн өрөнхий судалгааг гаргаж ирэх оны үндсэн чиглэл, төсвийн төсөлд тусгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.3.4. Хуулийн этгээдийн тухайн жилийн төсөвт тусгагдсан болон хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгийн худалдан авах үйл ажиллагааны арга, хэлбэрийг сонгож техникийн нэхцэл гаргах үйл ажиллагааг зохион байгуулна.